



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

___ оны ___ сарын ___ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Тайлангийн маягт батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.9, 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайлангийн маягт”-ыг 1 дүгээр, “Үнэ шилжилтийн ажил гүйлгээний жилийн тайланг нөхөх заавар”-ыг 2 дугаар, “Үнэ шилжилтийн тайлангийн тогтмол мэдээлэл”-ийг 3 дугаар, “Дотоод үнэ шилжилтийн тайлангийн маягт”-ыг 4 дүгээр, “Дотоод үнэ шилжилтийн тайланг нөхөх заавар”-ыг 5 дугаар, “Ерөнхий үнэ шилжилтийн тайлангийн маягт”-ыг 6 дугаар, “Ерөнхий үнэ шилжилтийн тайланг нөхөх заавар”-ыг 7 дугаар “Улс бүрээр үнэ шилжилтийн тайлангийн маягт”-ыг 8 дугаар, “Улс бүрээр үнэ шилжилтийн тайланг нөхөх заавар”-ыг 9 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон харьяа нэгжийн дарга нарт даалгасугай.

3.Батлагдсан журмыг цахим татварын системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Татварын удирдлага, хамтын ажиллагааны газар /Ц.Энхжавхлан/, Татвар төлөгчтэй харилцах газар /Д.Цогзолмаа/, Мэдээллийн технологи, статистикийн төв /Х.Батбаяр/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД
ДЭД ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



ТЕГ-ын даргын 2019 оны ... сарын
... өдрийн ... тушаалын ... хавсралт

Монголын Татварын Алба

Маягт АГТ-01

ҮНЭ ШИЛЖИЛТИЙН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАН

1. ТТД | | | | | | | | | | | |

2. Нэр: _____

3. Хариуцлагын хэлбэр: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагааны чиглэл

код | | | | | | | |

5. Тайлант хугацаа: он | | | | | улирал | |

А. ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ЭТГЭЭДИЙН ТАТВАРЫН ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛ:

6. Группийн толгой компани эсхүл удирдах байгууллагын талаарх мэдээлэл

№	Толгой компани эсхүл удирдах газрын нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Татвар төлөгчийн дугаар	Байнгын хаяг	Албан ёсны цахим хуудасны хаяг
0	1	2	3	4	5

7. Харилцан хамааралтай этгээдийн талаарх мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Харилцан хамааралтай этгээдийн төрөл	Харилцан хамаарлын н хэлбэр	Харилцан хамаарлын оролцоо	Эзэмшиж буй хувьцаа, хувь оролцооны хувь хэмжээ	Эзэмшиж буй саналын эрхийн хувь хэмжээ	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Байнгын хаяг
0	1	2	3	4	5	6	7	8	9

8. Тайлант хугацаанд бүтэц, зохион байгуулалтаар өөрчлөн байгуулагдсан харилцан хамааралтай этгээд болон салбар, төлөөний газрын мэдээлэл

№	Өөрчлөн байгуулагдсан этгээд, салбар, төлөөний газрын ТТД	Өөрчлөн байгуулагдсан этгээд, салбар, төлөөний газрын нэр	Харилцан хамааралтай этгээдийн төрөл	Харилцан хамаарлын хэлбэр	Өөрчлөн байгуулагдсаны		Өөрчлөн байгуулаг дсан шалтгаан	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Байнгын хаяг
					Өмнөх хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	Дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн			
0	1	2	3	4	5	6	7	8	9



Б. ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ЭТГЭЭДТЭЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

9. Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний нэгтгэл

№	Бараа, ажил гүйлгээний нэр, төрөл	Монгол улсад байрладаг этгээд		Монгол улсад байрладаггүй этгээд	
		Худалдан авалтын нийт дүн (төгрөг)	Борлуулалтын нийт дүн (төгрөг)	Худалдан авалтын нийт дүн (төгрөг)	Борлуулалтын нийт дүн (төгрөг)
0	1	2	3	4	5
	Бараа, ажил гүйлгээний нийт дүн				

10. Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Харилцан хамааралтай этгээдийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагааны чиглэл	Ажил гүйлгээний нэр, төрөл	Нийт дүн (төгрөг)	Үнэ шилжилтийн тохируулга хийсэн хамгийн тохиромжтой арга
0	1	2	3	4	5	6	7	8	9
	Нийт дүн								

11. Харилцан хамааралтай этгээдээс авсан ажил гүйлгээний худалдан авалтын дэлгэрэнгүй мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагааны чиглэл	Харилцан хамааралтай этгээдийн ангилал	Ажил гүйлгээний нэр, төрөл	Нийт дүн (төгрөг)	Үнэ шилжилтийн тохируулга хийсэн хамгийн тохиромжтой арга
0	1	2	3	4	5	6	7	8	9
	Нийт дүн								

12. Харилцан хамааралтай этгээдээс авсан зээлийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Зээлийн					
					Эхний үлдэгдэл	Авсан нэмэлт зээлийн дүн	Зээл төлөлтийн дүн	Эцсийн үлдэгдэл	Хүүний төлбөрийн дүн	Хүүний хувь хэмжээ
0	1	2	3	4	5	6	7	8	9	10



13. Харилцан хамааралтай этгээдэд олгосон зээлийн дэлгэрэнгүй мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Зээлийн					
					Эхний үлдэгдэл	Олгосон нэмэлт зээлийн дүн	Зээл төлөлтийн дүн	Эцсийн үлдэгдэл	Хүүний орлогын дүн	Хүүний хувь хэмжээ
0	1	2	3	4	5	6	7	8	9	10

14. Харилцан хамааралтай этгээдтэй үнэ төлбөргүйгээр хийсэн ажил гүйлгээний мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагаа нь чиглэл	Бараа, ажил гүйлгээний нэр, төрөл
0	1	2	3	4	5	6

15. Харилцан хамааралтай этгээдтэй солилцсон ажил гүйлгээний мэдээлэл

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагаа нь чиглэл	Солилцсон		Сольж авсан ажил гүйлчлэгээний нэр, төрөл
						Бараа, ажил үйлчилгээний нэр, төрөл	Бараа, ажил үйлчилгээний нийт дүн	
0	1	2	3	4	5	6	7	

16. Зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээгээр зохицуулсан ажил гүйлгээ

№	Гэрээнд оролцогч талуудын ТТД	Гэрээнд оролцогч талуудын нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагаа нь чиглэл	Хэрэгжүүлэх хугацаа /жил/	Гэрээгээр зохицуулсан			
						Нийт зардал, санхүүжилтийн дүн	Хөрөнгө, ажил үйлчилгээний нэр, төрөл	Хувь оруулсан, санхүүжүүлсэн хөрөнгийн дүн	Хүлээгдэж байгаа ашгийн хувь хэмжээ
0	1	2	3	4	5	6	7	8	9

17. Татвар төлөгчийн болон харилцан хамааралтай этгээдийн эзэмшиж буй биет бус хөрөнгийн жагсаалт

Биет бус хөрөнгө эзэмшиж буй компанийн ТТД	Биет бус хөрөнгө эзэмшиж буй компанийн нэр	Биет бус хөрөнгийн нэр, төрөл	Бүртгүүлсэн улсын код	Биет бус хөрөнгийн зориулалт, товч утга, агуулга

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /захирал/:

..... /...../
гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын байцаагч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр



“ҮНЭ ШИЛЖИЛТИЙН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ЖИЛИЙН ТАЙЛАН - АГТ-01 МАЯГТ”-ЫГ НӨХӨХ ЗААВАР

1.Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-т заасан татвар төлөгч аж ахуйн нэгж дотоод үнэ шилжилтийн тайланг энэ маягтын дагуу үйлдэж, жилийн эцсийн татварын тайлангийн хамт татварын албанд тушаана. Тайланг гаргахдаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан “Үнэ шилжилтийн зөвлөмж”, Сангийн сайдын 2019 оны . . . дугаар сарын. . . өдрийн . . . дүгээр тушаалаар батлагдсан “Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”-ыг баримтална.

2.Татвар төлөгч нь тайлангийн маягтаар Монгол Улсад байрладаг болон Монгол Улсад байрладаггүй харилцан хамааралтай этгээдийн татварын төлөгчийн бүртгэлийн мэдээлэл, тэдгээртэй хийсэн ажил гүйлгээний нэгтгэл, дэлгэрэнгүй мэдээллийг өссөн дүнгээр гаргана.

3.Харилцан хамааралтай этгээдийн ангилал, төрөл, харилцан хамаарлын хэлбэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код, ажил гүйлгээний нэр, төрөл хэсгийг хавсралт 3-т заасан дугаарыг ашиглан нөхнө.

4.Бүх ажил гүйлгээнээс онцлог, тусгайлсан ажил гүйлгээний мэдээллийг тайлангийн 12, 13, 14, 15, 16, 17 дахь хэсэгт тодруулан гаргана.

5.Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу үнэ шилжилтийн тайлантай холбогдох нэмэлт мэдээллийг татварын албанд тухай бүр гаргаж өгнө.

6.Тайлангийн 6 дахь группийн толгой компани эсхүл удирдах байгууллагын мэдээлэл хэсэгт - Монгол Улсад байрладаггүй гадаад улсын толгой компани, удирдах байгууллага байгаа тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр/оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, байнгын хаяг, албан ёсны цахим хуудасны хаяг зэрэг ерөнхий мэдээллийг тус тус тусгана.

7.Тайлангийн 7 дахь харилцан хамааралтай этгээдийн мэдээлэл хэсэгт - Монгол Улсад байрладаггүй гадаад улсын харилцан хамааралтай этгээд байгаа бол тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, харилцан хамааралтай этгээдийн төрөл, харилцан хамаарлын хэлбэр, оролцоо, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, эзэмшиж буй хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн хувь хэмжээг компанийн дүрэмд тусгасан дүрмийн сангийн тухайн тайлант хугацааны эцсийн дүнгээр, ажиллагсдын тоо, албан ёсны байнгын хаяг зэрэг мэдээллийг хүснэгтээр.

8.Тайлангийн 8 дахь тайлант хугацаанд бүтэц, зохион байгуулалтаар өөрчлөн байгуулагдсан харилцан хамааралтай этгээд болон салбар, төлөөний газрын мэдээлэл хэсэгт - өөрчлөн байгуулагдсан этгээд, салбар, төлөөний газрын нэр, тэдгээрийн татвар төлөгчийн дугаар, өөрчлөн байгуулагдсаны өмнөх болон дараах хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн, түүний шалтгааныг улсын бүртгэлийн гэрчилгээнд хийгдсэн өөрчлөлт, компанийн шинэчилсэн дүрмийг үндэслэн бэлтгэнэ. Харилцан хамааралтай этгээдийн төрөл, харилцан хамаарлын хэлбэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг ашиглана. Монгол Улсад байрладаггүй харилцан хамааралтай этгээдийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгдсэн тохиолдолд тухайн улсын хуулиар зохицуулсны дагуу харгалзах мөрүүдийг бөглөнө.



9.Тайлангийн 9 дэх Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний нэгтгэл хэсэгт - харилцан хамааралтай этгээдийг Монгол Улсад байрладаг, байрладаггүйгээр ангилан хавсралт 3-т заасан ажил гүйлгээ /худалдан авалт, борлуулалт/-ний нэр, төрөл тус бүрээр нэгтгэн харуулна.

10.Тайлангийн 10, 11 дэх харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалт, худалдан авалтын дэлгэрэнгүй мэдээллийн хэсэгт – тайлангийн 9 дэх хэсгийн дүнг ажил гүйлгээ тус бүрээр дэлгэрэнгүй задалж харуулна. Харилцан хамааралтай этгээдийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Монгол улсад байрладаг, байрладаггүйгээр ангилан “татвар төлөгчийн ангилал” баганад бичнэ.Харилцан хамааралтай этгээдийн төрөл, ажил гүйлгээний нэр, төрөл, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-ыг тус тус ашиглана.Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”-ын дагуу тодорхойлсон ажил гүйлгээний дүн, аргыг тохирох баганад нь бөглөнө.

11.Тайлангийн 12 дахь харилцан хамааралтай этгээдээс авсан зээлийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийн хэсэгт - зээл авсан харилцан хамааралтай этгээд нь Монгол Улсад байрладаггүй этгээд байгаа тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг бөглөнө. Харилцан хамааралтай этгээдийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Монгол улсад байрладаг, байрладаггүйгээр ангилан “татвар төлөгчийн ангилал” баганад бичнэ. Харилцан хамааралтай этгээд тус бүрээр авсан зээлийн мэдээлэл болох тухайн тайлант хугацааны зээлийн эхний үлдэгдэл, нэмж авсан зээлийн дүн, зээл төлөлтийн дүн, эцсийн үлдэгдэл, хүүгийн төлбөрийн дүн, хувь хэмжээг зээлийн гэрээ болон зээлийн холбогдох дансны мэдээллийг үндэслэн гаргана.

12.Тайлангийн 13 дахь харилцан хамааралтай этгээдэд олгосон зээлийн үйлчилгээний дэлгэрэнгүй мэдээллийн хэсэгт- зээл олгосон харилцан хамааралтай этгээд нь Монгол Улсад байрладаггүй этгээд байгаа тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг бөглөнө. Мөн харилцан хамааралтай этгээдийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Монгол Улсад байрладаг, байрладаггүйгээр ангилан “Татвар төлөгчийн ангилал” баганад бичнэ. Харилцан хамааралтай этгээд тус бүрээр олгосон зээлийн мэдээлэл болох тухайн тайлант хугацааны зээлийн эхний үлдэгдэл, нэмж олгосон, төлсөн дүн, эцсийн үлдэгдэл, хүүний орлогын дүн, хувь хэмжээг зээлийн гэрээ болон зээлийн холбогдох дансны мэдээллийг үндэслэн гаргана.

13.Тайлангийн 14 дэх харилцан хамааралтай этгээдтэй үнэ төлбөргүйгээр хийсэн ажил гүйлгээний мэдээлэл хэсэгт - үнэ төлбөргүй бараа, ажил үйлчилгээ борлуулсан, худалдан авсан харилцан хамааралтай этгээд нь Монгол Улсад байрладаггүй этгээд байгаа тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код, ажил гүйлгээний нэр, төрлийг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг ашиглан бөглөнө. Харилцан хамааралтай этгээдийг “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Монгол Улсад байрладаг, байрладаггүйгээр ангилан “Татвар төлөгчийн ангилал” баганад бичнэ. Тус этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д заасны дагуу бөглөнө.

14.Тайлангийн 15 дахь харилцан хамааралтай этгээдтэй солилцсон ажил гүйлгээний мэдээлэл хэсэгт - тайлангийн 14 дэх хэсэгт заасан харгалзах утгатай адил бөглөх бөгөөд



зөвхөн тайлант хугацаанд солилцсон болон сольж авсан ажил гүйлгээний нэр төрөл, дүнг тодорхой тусгаж өгнө.

15.Тайлангийн 16 дахь зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээгээр зохицуулсан ажил гүйлгээ хэсэгт – гэрээний заалтыг үндэслэн оролцогч талуудын нэр, татвар төлөгчийн дугаар, хэрэгжүүлэх хугацаа /жилээр/, гэрээгээр зохицуулсан нийт зардал, санхүүжилтийн дүн, хөрөнгө, ажил үйлчилгээний нэр, төрөл, хувь оруулсан, санхүүжүүлсэн хөрөнгийн дүн, хүлээгдэж байгаа ашгийн хувь хэмжээ /гэрээнээс хүртэх өгөөж/-г тодорхой тусгана. Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д заасны дагуу тус тус бөглөнө.

16.Тайлангийн 17 дахь татвар төлөгчийн болон харилцан хамааралтай этгээдийн эзэмшиж байгаа биет бус хөрөнгийн жагсаалт хэсэгт - биет бус хөрөнгө эзэмшиж байгаа компанийн нэр, регистрийн дугаар, биет бус хөрөнгийн нэр, төрөл, хөрөнгийн зориулалт, шинж чанар, судалгаа хөгжүүлэлт зэрэг мэдээллийг тусгана. Харин бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг ашиглана.



ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН ТОГТМОЛ МЭДЭЭЛЭЛ

“Харилцан хамааралтай этгээд” гэж Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу ойлгоно. “Харилцан хамааралтай этгээдийн төрөл”-ийг дээрх хуулийн 27 дугаар зүйлд нийцүүлэн дараах хүснэгтэд тусгасан дугаарын дагуу нөхнө. Үүнд:

1.Харилцан хамааралтай этгээдийн төрөл:

д/д	Харилцан хамааралтай этгээдийн төрөл	Дугаар
1	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-д заасан группт хамаарах этгээд	27121
2	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-д заасан хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар эзэмшдэг этгээд;	27131
3	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.4-д заасан ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй этгээд;	27141
4	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5-д заасан хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийн 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар эзэмшдэг аж ахуйн нэгж;	27151
5	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.6-д заасан ашиг, эсхүл татан буугдсаны дараах үлдэгдэл хөрөнгөөс 20 ба түүнээс доошгүй хувийг гуравдагч этгээд шууд болон шууд бусаар хүртэх эрхтэй аж ахуйн нэгж;	27161
6	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-д заасан татвар төлөгчийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, хүүхэд, өвөг эцэг, эмэг эх, ач, зээ болон эхнэр /нөхөр/, хамтран амьдрагч, тэдгээрийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүүгийн шууд болон шууд бус эзэмшил дэх харилцаа бүхий этгээд;	27171
7	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8-д заасан харилцан хамааралтай этгээд, тэдгээрийг томилох эрхтэй этгээд, тэдгээрийн эрх, үүргийг шилжүүлэн хүлээж авсан этгээд, эсхүл тэдгээрийг төлөөлөхөөр сонгогдсон этгээд;	27181
8	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9-д заасан харилцан хамааралтай этгээд,болон харилцан хамаарал бүхий аж ахуйн нэгжийн салбар, төлөөний газар зэрэг;	27191
9	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.10-д заасан Монгол Улсад оршин суугч татвар төлөгчийн татвар ногдуулах орлогыг бууруулах, алдагдлыг өсгөх үндсэн зорилгоор харилцаа тогтоосон этгээд;	271101
10	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.11-д заасан адилтгах бусад этгээд.	27111
11	Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-д заасан Хувь нийлүүлэгчид шууд болон шууд бусаар аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны шийдвэр гаргахад нэгдмэл байр суурьтай оролцохоор хэлцэл байгуулж, уг хэлцлийн үндсэн дээр шийдвэр гаргадаг бол тухайн хувь нийлүүлэгч этгээдийг хувь, оролцооны хувьд нэг этгээд гэж үзнэ.	27200

3.Харилцан хамаарлын хэлбэр:

д/д	Харилцан хамаарлын хэлбэр
1	Хөрөнгө
2	Удирдлага
3	Хяналт

4.Харилцан хамаарлын оролцоо:

д/д	Харилцан хамаарлын оролцоо:
-----	-----------------------------



1	Шууд
2	Шууд бус

5.Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код:

Улсын нэр	Улсын код	Улсын нэр	Улсын код	Улсын нэр	Улсын код
Америкийн Нэгдсэн Улс	1	Бүгд Найрамдах Чили Улс	56	Швейцарын холбооны Улс	410
Бүгд Найрамдах Ангол Ард Улс	2	Бүгд Найрамдах Колумб Улс	57	Бүгд Найрамдах Чех Улс	420
Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	3	Бүгд Найрамдах Венесуэль Улс	58	Бүгд Найрамдах Никарагуа Улс	505
Джибути улс	4	Малайз Улс	60	Бүгд Найрамдах Панам Улс	507
Доминиканы Бүгд Найрамдах Улс	5	Австрали Улс	61	Бүгд Найрамдах Боливи Улс	591
Эли Сальвадор	6	Бүгд Найрамдах Индонез Улс	62	Бүгд Найрамдах Парагвай Улс	597
Оросын Холбооны Улс	7	Бүгд Найрамдах Филиппин Улс	63	Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улс	598
Гүрж Улс	8	Шинэ Зеланд Улс	64	Хойд Марианы Арлууд /Сейпан/	670
Гана	9	Бүгд Найрамдах Сингапур Улс	65	Гуам	671
Бүгд Найрамдах Гайана Улс	10	Тайландын Вант Улс	66	Бруней Даруссалам улс	673
Ямаик Улс	11	Арабын Нэгдсэн Эмират Улс	67	Фижийн арлуудын Бүгд Найрамдах Улс	679
Жерси	12	Япон Улс	81	Бүгд Найрамдах Палау Улс	680
Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	13	Бүгд Найрамдах Солонгос Улс	82	Шинэ Каледони	687
Бүгд Найрамдах Македон Улс	15	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	84	Полинези	689
Бүгд Найрамдах Мадагаскар Улс	16	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	86	Холбооны Микронез Улс	691
Бүгд Найрамдах Мальдив Улс	17	Бүгд Найрамдах Турк Улс	90	Маршаллын арлуудын Бүгд Найрамдах Улс	692
Бүгд Найрамдах Мальт Улс	18	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	91	Бүгд Найрамдах Тажикистан Улс	701
Бүгд Найрамдах Монтенегро Улс	19	Лалын Бүгд Найрамдах Пакистан Улс	92	Бүгд Найрамдах Узбекистан Улс	702
Арабын Бүгд Найрамдах Египет Улс	20	Лалын шилжилтийн Афганистан Улс	93	Бүгд Найрамдах Казахстан Улс	703
Бүгд Найрамдах Мозамбик Улс	21	Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шриланк Улс	94	Бүгд Найрамдах Азербайджан Улс	704
Реюнион /БНФУ/	22	Мьянманийн Холбооны Улс	95	Бүгд Найрамдах Латви Улс	705
Бүгд Найрамдах Словек Улс	23	Лалын Бүгд Найрамдах Иран Улс	98	Бүгд Найрамдах Литва Улс	706
Сент-Люси Улс	24	Канад Улс	100	Бүгд Найрамдах Эстони Улс	707
Бүгд Найрамдах Ардчилсан Судан Улс	25	Мароккын Вант Улс	212	Бүгд Найрамдах Армян Улс	708
Тринидад Тобаго улс	26	Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улс	213	Бүгд Найрамдах Молдов Улс	709
Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	27	Бүгд Найрамдах Тунис Улс	216	Бүгд Найрамдах Ливан Улс	710
Бүгд Найрамдах Уганда Улс	28	Бүгд Найрамдах Ливан Улс	218	Украйн Улс	711



Бүгд Найрамдах Вануату Улс	29	Бүгд Найрамдах Гамби Улс	220	Кайманы арлууд	712
Бүгд Найрамдах Грек Улс	30	Бүгд Найрамдах Сенегал Улс	221	Антигуа-Барбуда Улс	713
Нидерландын Вант Улс	31	Папуа Шинэ Гвиней Улс	224	Бермудын арал	714
Бельгийн Вант Улс	32	Бүгд Найрамдах Нигер Улс	227	Бахамын арлууд	715
Бүгд Найрамдах Франц Улс	33	Мавритани Улс	230	Арабын Бүгд Найрамдах Сири Улс	717
Испани Улс	34	Сьерра Леон Улс	232	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс	850
Унгар Улс	36	Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улс	251	Хонг Конг /БНХАУ/	852
Бүгд Найрамдах Серби Улс	38	Бүгд Найрамдах Кени Улс	254	Макао /БНХАУ/	853
Бүгд Найрамдах Итали Улс	39	Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс	255	Камбожийн Вант Улс	855
Румын Улс	40	Бүгд Найрамдах Замби Улс	260	Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс	880
Лихтенштейний Вант Улс	41	Бүгд Найрамдах Малави Улс	265	Тайвань /БНХАУ/	886
Бүгд Найрамдах Словак Улс	42	Гебралтар улс	350	Йорданы хашимитын Вант Улс	962
Бүгд Найрамдах Австри Улс	43	Бүгд Найрамдах Португал Улс	351	Кувейт Улс	965
Их Британи, Умард Ирландын нэгдсэн вант улс	44	Люксембургийн их Вант улс	352	Саудын Арабын Вант Улс	966
Данийн Вант Улс	45	Бүгд Найрамдах Ирланд Улс	353	Бүгд Найрамдах Йемен Улс	967
Шведийн Вант Улс	46	Бүгд Найрамдах Исланд Улс	354	Оманы Султант Улс	968
Норвегийн Вант Улс	47	Бүгд Найрамдах Албани Улс	355	Израиль Улс	972
Бүгд Найрамдах Польш Улс	48	Бүгд Найрамдах Кипр Улс	357	Бахрейн Улс	973
Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	49	Бүгд Найрамдах Финланд Улс	358	Катар Улс	974
Бүгд Найрамдах Перу Улс	51	Бүгд Найрамдах Болгар Улс	359	Монгол Улс	976
Мексикийн Нэгдсэн Улс	52	Бүгд Найрамдах Беларусь Улс	375	Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс	977
Бүгд Найрамдах Куба Улс	53	Монакогийн Вант улс	377	Бүгд Найрамдах Хорват Улс	981
Бүгд Найрамдах Аргентин Улс	54	Серби Улс	381	Бүгд Найрамдах Киргиз Улс	996
Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс	55	Бүгд Найрамдах Сан-Марино Улс	390		

6.Бараа, ажил гүйлгээний нэр, төрөл:

д/д	Ажил гүйлгээний нэр	Ажил гүйлгээний төрөл	Дугаар-лалт
1	Хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээ	Бараа бүтээгдэхүүн	0101
		Хөдлөх хөрөнгө	0102
		Үл хөдлөх хөрөнгө	0103
		Бусад	0104
2	Биет бус хөрөнгөтэй холбоотой ажил	Лицензийн төлбөр	0201
		Патент	0202
		Зохиогчийн эрх	0203
		Худалдааны болон барааны тэмдэг	0204
		Франчайзингийн эрх	0205
		Өмчийн ба байгалийн нөөц ашиглах эрх	0206



	гүйлгээ	Программ хангамж	0207
		Хаяас болон гүүдвил	0208
		Түрээсийн эрх	0209
		Ашиглах, өмчлөх, эзэмших эрх	0210
		Ноу-Хау	0211
		Бусад	0212
3	Түрээстэй холбоотой ажил гүйлгээ		03
4	Үйлчилгээтэй холбоотой ажил гүйлгээ	Удирдлагын үйлчилгээ	0401
		Зөвлөх үйлчилгээ	0402
		Санхүүгийн үйлчилгээ	0403
		Даатгалын үйлчилгээ	0404
		Давхар даатгалын үйлчилгээ	0405
		Судалгаа болон хөгжлийн үйлчилгээ	0406
		Борлуулалт болон маркетингийн үйлчилгээ	0407
		Мэдээлэл технологийн үйлчилгээ	0408
		Техникийн, логистик үйлчилгээ	0409
		Агентын үйлчилгээ	0410
		Дистрибютөрийн үйлчилгээ	0411
		Эрхийн шимтгэлийн үйлчилгээ	0412
		Бусад үйлчилгээ	0413
5	Санхүүжилттэй холбоотой ажил гүйлгээ	Баталгаа гаргах	0501
		Зээл авах	0502
		Зээл олгох	0503
		Ногдол ашиг	0504
		Бусад	0505
6	Дээрх ажил гүйлгээнээс бусад ажил гүйлгээ		06

7.Өөрчлөн байгуулагдсан шалтгаан:

№	Өөрчлөн байгуулагдсан шалтгаан
1	Компанийг нийлүүлэх
2	Компанийг нэгтгэх
3	Компанийг хуваах
4	Компанийг тусгаарлах
5	Компанийг өөрчлөх
6	Компанийг татан буулгах
7	Компанийн дүрмийн санг өөрчлөх
8	Бусад





ТЕГ-ын даргын 2019 оны ... сарын
... өдрийн ... тушаалын ... хавсралт

Монголын Татварын Алба

Маягт ДҮШТ-01

ДОТООД ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАН

1. ТТД | | | | | | | | | | | |

2. Нэр: _____

3. Хариуцлагын хэлбэр: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагааны чиглэл
_____ код | | | | | | | |

5. Тайлант хугацаа: он | | | | | улирал | |

6. ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

6.1. Татвар төлөгчийн талаарх танилцуулга

6.2. Шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал (Зурган хэлбэрээр оруулна)

6.3 Татвар төлөгчийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл (Зурган хэлбэрээр оруулна)

6.4. Дотоод нэгжүүдийн ажил үүргийн хуваарилалт, зохион байгуулалтын мэдээлэл (Зурган болон бичгийн хэлбэрээр оруулна)

6.5. Удирдлагын тайлан, мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт

№	Эрх бүхий албан тушаалтны овог, нэр	Албан тушаал	Ажилладаг компанийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Байнгын хаяг	Дотоод болон гадаадад тайлагнадаг тайлангийн нэр, товч агуулга
0	1	2	3	4	5	6



6.6.Бизнесийн үйл ажиллагаа болон стратеги

/Татвар төлөгч нь шууд болон шууд бус харилцан хамааралтай этгээдийн өмнөх оны болон тухайн татварын жилийн бүтэц болон зохион байгуулалтын өөрчлөлт нь,биет бус хөрөнгийн шилжүүлэлт нь тухайн татвар төлөгчид үзүүлсэн нөлөөлөл нэмж тусгана./

--

6.7.Гол өрсөлдөгч хуулийн этгээдийн мэдээлэл

№	Өрсөлдөгч хуулийн этгээдийн ТТД	Өрсөлдөгч хуулийн этгээдийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагааны салбарын ангилал	Үйлдвэрлэж буй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр, тэмдэг
0	1	2	4	5	6

7.ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ЭТГЭЭДТЭЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР:

7.1 Тухайн компанийн хувь нийлүүлэгчдийн мэдээлэл

№	Хувьцаа эзэмшигч этгээдийн ТТД	Хувьцаа эзэмшигч этгээдийн нэр	Хөрөнгө оруулалтын хэлбэр	Тайлант хугацааны эхэнд эзэмшиж буй		Тайлант хугацааны эцэст эзэмшиж буй		Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Байнгын хаяг
				Хувьцаа ны тоо (ширхэг)	Хувьцаа ны нийт дүн	Хувьцаа ны тоо (ширхэг)	Хувьцаа ны нийт дүн		
0	1	2	3	4	5	6	7	8	9

7.2.Харилцан хамааралтай этгээдийн бүтцийн зураглал /Зурган хэлбэрээр оруулна/

--

7.3.Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл /ажил гүйлгээ, харилцан хамааралтай этгээд тус бүрээр/

№	Харилцан хамааралтай этгээдийн ТТД	Харилцан хамааралтай этгээдийн нэр	Татвар төлөгчийн ангилал	Харилцан хамааралтай этгээдийн төрөл	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Үйл ажиллагааны чиглэл	Ажил гүйлгээний нэр, төрөл	Нийт дүн (төгрөг)	Гэрээтэй эсэх
0	1	2	3	4	5	6	7	8	9
	Нийт дүн								



7.10. Сонгосон харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ /дотоод, гадаад/-ний жагсаалт, үнэ шилжилтийн шинжилгээнд ашигласан харьцуулагдах аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үзүүлэлтүүд, харьцуулалт хийсэн арга, аргачлал, харьцуулалт хийсэн мэдээллийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл

А. Сонгосон харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ /дотоод, гадаад/-ний тайлбар, жагсаалт

--

Б. Харьцуулагдах зүйлсийг олж тогтооход ашигласан мэдээллийн эх үүсвэр, тэдгээрийг хайлт хийхэд хэрэглэсэн арга аргачлалыг дэлгэрэнгүй тайлбар

--

В. Сонгосон харьцуулагдах компанийн шалгуур үзүүлэлт

Шалгуур үзүүлэлт	Сонгосон	Татгалзсан

Г. Сонгосон харьцуулагдах компанийн санхүүгийн мэдээлэл

Сонгосон компани 1.

/төгрөг/

Үзүүлэлт		 он	 он	 он	 он
Тохируулга хийхийн өмнө	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				
	...				
Тохируулга хийсний дараа	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				
	...				

Сонгосон компани 2.

/төгрөг/

Үзүүлэлт		 он	 он	 он	 он
Тохируулга хийхийн өмнө	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				



	...				
	...				
Тохируулга хийсний дараа	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				
	...				
	...				

7.11. Харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ эсвэл харьцуулагдах талуудад хийсэн тохируулгын үзүүлэлт болон хийсэн тохируулгын талаар дэлгэрэнгүй тайлбар

--

7.12. Үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой аргыг хэрэглэсэн дүгнэлт (шаардлагатай тохиолдолд дүгнэлт, шинжилгээ, тайлбарыг олон жилээр нь харуулж болно.)

--

7.13. Үнэ шилжилтийн аргуудыг хэрэглэх үед болон хэрэглэсний дараа ашигласан санхүүгийн мэдээллийн нэгтгэл (төгрөг)

	Үзүүлэлт	 ОН	 ОН	 ОН	 ОН
Тохируулга хийхийн өмнө	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				
	...				
	...				
Тохируулга хийсний дараа	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 1				
	Үзүүлэлт 1				
	Үзүүлэлт 2				
	Санхүүгийн харьцаа, өгөөж № 2				
	...				
	...				
	...				

7.14. Сонгосон харьцуулагдах компаниудын квартилийн хязгаар (Inter-quartile range) (%)

Компанийн нэр	 ОН	 ОН	 ОН	 ОН



Тайлагнагч аж ахуйн нэгж					
Харьцуулалт	Дээд квартил				
	Медиан				
	Доод квартил				
	Тохируулга (Тийм, Үгүй)				

7.15. Дүгнэлт (Ажил гүйлгээг бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу тодорхойлсон дүгнэлт)

--

8. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ГЭРЭЭ

8.1 Татвар төлөгчийн санхүүгийн тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайлан (pdf файлаар хавсаргана)

д/д	Санхүүгийн тайлангийн төрөл	Санхүүгийн жил	Хуудасны тоо	Тайлан ирүүлээгүй шалтгаан

8.2 Дээрх харилцан хамааралтай гүйлгээтэй холбоотой гадаад орны татварын байгууллагатай байгуулсан хоёр талт, олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, тэдгээрийн гаргасан дүрэм, журмын хуулбар (pdf файлаар хавсаргана)

д/д	Гэрээ байгуулсан улсын нэр	Гэрээ байгуулсан хугацаа	Товч агуулга

8.3 Татвар төлөгч харилцан хамааралтай этгээдүүдийн хооронд байгуулсан их хэмжээний гэрээ, хэлцлийн хуулбар (pdf файлаар хавсаргана)

д/д	Гэрээ байгуулсан харилцан хамааралтай этгээдийн нэр	Гэрээний хугацаа	Товч агуулга



ДОТООД ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН БАРИМТЖУУЛАЛТЫН БҮРДЭЛ

Үзүүлэлт	Хуудасны дугаар	Ирүүлээгүй шалтгаан
6. ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:		
6.1 Татвар төлөгчийн талаарх танилцуулга		
6.2 Шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал		
6.3 Татвар төлөгчийн удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл		
6.4 Дотоод нэгжүүдийн ажил үүргийн хувиарлалт, зохион байгуулалтын мэдээлэл		
6.5 Удирдлагын тайлан, мэдээлэлийг танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт		
6.6 Бизнесийн үйл ажиллагаа болон стратеги		
6.7 Гол өрсөлдөгч хуулийн этгээдийн мэдээлэл		
7.ХАРИЛЦАН ХАМААРАЛТАЙ ЭТГЭЭДТЭЙ ХИЙСЭН АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР:		
7.1 Тухайн тайлангийн жилд ажил гүйлгээ хийсэн харилцан хамааралтай этгээдийн татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл		
7.2 Харилцан хамааралтай этгээдийн хувь нийлүүлэгчидийн мэдээлэл		
7.3 Харилцан хамааралтай этгээдийн хувь нийлүүлэгчидийн бүтэц		
7.4 Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалтын дэлгэрэнгүй мэдээлэл		
7.5 Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний худалдан авалтын дэлгэрэнгүй мэдээлэл		
7.6 Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн томоохон ажил гүйлгээний нарийвчилсан мэдээлэл		
7.7 Өмнөх болон тухайн татварын жилийн харьцуулагдах байдлын шинжилгээний талаар:		
7.8 Харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээнд ашигласан үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой арга		
7.9 Шалгагдах талуудыг сонгосон үзүүлэлт, шалтгаан		
7.10 Үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой аргыг хэрэглэсэндүгнэлт		
7.11 Сонгосон харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ (дотоод, гадаад)-ний жагсаалт, үнэ шилжилтийн шинжилгээнд ашигласан харьцуулагдах аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн үзүүлэлтүүд, харьцуулалт хийсэн арга, аргачлал, харьцуулалт хийсэн мэдээлэлийн эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээлэл		
7.12 Харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ эсвэл харьцуулагдах талуудад хийсэн тохируулгын үзүүлэлт болон хийсэн тохируулга талаар дэлгэрэнгүй тайлбар		
7.13 Үнэ шилжилтийн аргуудыг хэрэглэх үед болон хэрэглэсний дараа ашигласан санхүүгийн мэдээлэлийн нэгтгэл		
7.14 Сонгосон харьцуулагдах компаниудын квартилийн хязгаар (Inter-quartile range)		
7.15 Дүгнэлт (Шалгагдах ажил гүйлгээг бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу тодорхойлсон дүгнэлт)		
8. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ БОЛОН ГЭРЭЭНИЙ ТАЛААР:		
8.1 Татвар төлөгчийн санхүүгийн тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайлан (pdf файлаар хавсаргана)		
8.2 Дээрх харилцан хамааралтай гүйлгээтэй холбоотой гадаад орны татварын байгууллагатай байгуулсан хоёр талт, олон талт Урьдчилан үнэ тохирох гэрээ, тэдгээрийн гаргасан дүрэм, журмын хуулбар (pdf файлаар хавсаргана)		
8.3 Татвар төлөгч харилцан хамааралтай этгээдийн хооронд байгуулсан их хэмжээний гэрээ, хэлцлийн хуулбар (pdf файлаар хавсаргана)		

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /захирал/:

..... /...../
гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын байцаагч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр

Албан татвар төлөгч нь энэ тайланг жилийн эцсийн тайлангийн хамт дараа оны 02 сарын 10-ны дотор харьяалах татварын албанд ирүүлнэ



“ДОТООД ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН (ДҮШТ-02) МАЯГТ”-ЫГ НӨХӨХ ЗААВАР

1. Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д заасан татвар төлөгч аж ахуйн нэгж дотоод үнэ шилжилтийн тайланг энэ маягтын дагуу үйлдэж, жилийн эцсийн татварын тайлангийн хамт татварын албанд тушаана. Тайланг гаргахдаа олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан “Үнэ шилжилтийн зөвлөмж”, “Үнэ шилжилтийн тайлан гаргах удирдамж”, Сангийн сайдын 2019 оны . . . дугаар сарын. . . өдрийн . . . дүгээр тушаалаар батлагдсан “Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”-ыг баримтална.

2. Татвар төлөгч нь тайлангийн маягтаар татвар төлөгчийн бизнесийн үйл ажиллагаа, харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, санхүүгийн мэдээлэл болон гэрээний дэлгэрэнгүй мэдээллийг жилийн эхнээс өссөн дүнгээр гаргана.

3. Харилцан хамааралтай этгээдийн ангилал, харилцан хамаарлын төрөл, хэлбэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код, ажил гүйлгээний нэр, төрөл хэсгийг нөхөхдөө хавсралт 3-т заасан дугаарыг ашиглана.

4. Тайлангийн маягтад дурдсан танилцуулга, бодлого, стратеги зэрэг бичгэн хэлбэрээр бэлтгэх мэдээллийг дэлгэрэнгүй, утга санаа нь тодорхой, агуулга ойлгомжтой, нотлогдохуйц байдлаар боловсруулна.

5. Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу үнэ шилжилтийн тайлантай холбогдох нэмэлт мэдээллийг татварын албанд тухай бүр гаргаж өгнө.

6. Татвар төлөгч нь тайланг боловсруулахдаа Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан дараах шаардлагатай мэдээллийг бүрэн тусгасан байна:

6.1. Татвар төлөгчийн бизнесийн үйл ажиллагааны талаар:

6.1.1. тайлангийн 6.1 дэх татвар төлөгчийн талаарх танилцуулга хэсэгт – компанийн түүх, үндсэн болон туслах үйл ажиллагаа, сүүлийн үеийн өөрчлөлт, зах зээлийн ерөнхий мэдээлэл /гол бэлтгэн нийлүүлэгч, захиалагч, худалдан авагч, үйлдвэрлэж байгаа бараа бүтээгдэхүүний талаар/;

6.1.2. тайлангийн 6.2 дахь шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал хэсэгт - тухайн компанийн гаргасан нийт хувьцаа, саналын эрхийг шууд болон шууд бусаар эзэмшиж буй харилцан хамааралтай этгээдийн хувь оролцоо болон үргэлжилсэн хэлхээ холбоог бүдүүвч зургаар;

6.1.3. тайлангийн 6.3 дахь удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл хэсэгт - компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан зэрэг хүний нөөцөд хамаарах албан тушаалтныг шатлан захирах зарчмаар байршуулсан бүтэц, зохион байгуулалтыг бүдүүвч зургаар;

6.1.4. тайлангийн 6.4 дэх дотоод нэгжүүдийн ажил үүргийн хуваарилалт, зохион байгуулалтын мэдээлэл хэсэгт - компанийн газар, хэлтэс, тасаг зэрэг дотоод нэгжүүдийн бүтэц зохион байгуулалт, тэдгээрийн ажил үүргийн хуваарилалт, ажиллагсдын тоо болон бусад мэдээллийг бүдүүвч зургаар болон бичгэн хэлбэрээр;

6.1.5. тайлангийн 6.5 дахь удирдлагын тайлан, мэдээллийг танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт хэсэгт - тухайн компанийн тайлан, холбогдох мэдээлэлтэй танилцах эрхтэй, удирдлагын шийдвэр гаргах түвшинд ажилладаг тус компанийн болон толгой компанийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг нэр, албан тушаал, ажилладаг компанийн нэр, хаяг, тайлангийн нэр, товч агуулгаар ангилан хүснэгтээр;

6.1.6. Тайлангийн 6.6 дахь бизнесийн үйл ажиллагаа болон стратеги хэсэгт - үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэлийн салбар, зах зээлийн орчин, төлөв байдал, эдийн засгийн, хууль эрхзүйн нөлөөлөл, бизнес, маркетингийн стратеги, бодлого, тайлант хугацаанд гарсан компанийн бүтцийн өөрчлөлт, тухайн компанийн бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц харилцан хамааралтай компанийн бүтцийн өөрчлөлт, эзэмшиж

байгаа биет бус хөрөнгө, түүний бодлого зэрэг тухайн компанийн бизнесийн үйл ажиллагаа болон стратегийг тусгасан бүх мэдээллийг бичгэн хэлбэрээр;

6.1.7.тайлангийн 6.7 дахь гол өрсөлдөгч хуулийн этгээдийн мэдээлэл хэсэгт - зах зээлд гол өрсөлдөгч хуулийн этгээдийн үйлдвэрлэж буй ижил төстэй бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр, тэмдэг зэрэг мэдээллийг хүснэгтээр;

6.2. Харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний талаар:

6.2.1.тайлангийн 7.1 дэх тухайн компанийн хувь нийлүүлэгчдийн мэдээлэл хэсэгт - Монгол Улсад байрладаг болон байрладаггүй хувьцаа эзэмшигчдийн уг компанид оруулсан хөрөнгө оруулалтыг хөрөнгөөр, мөнгөөр, хувьцаагаар ангилахаас гадна тайлант хугацааны эхэн, эцэс дэх хувьцааны мэдээллийг тодруулан хүснэгтээр;

6.2.2.тайлангийн 7.2 дахь харилцан хамааралтай этгээдийн бүтцийн зураглал хэсэгт – тайлант хугацаанд ажил гүйлгээ хийсэн Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд хамаарах этгээдийн хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн эзэмшлийг харуулсан бүтцийг бүдүүвч зургаар;

6.2.3.тайлангийн 7.3, 7.4 дэх харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээний борлуулалт, худалдан авалтын дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт - харилцан хамааралтай этгээд, ажил гүйлгээ тус бүрээр, гэрээ байгуулсан эсэхийг харуулна. Харилцан хамааралтай этгээдийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасны дагуу Монгол Улсад байрладаг, байрладаггүй эсэхээр нь ангилан “татвар төлөгчийн ангилал” баганад бичнэ. Харилцан хамааралтай этгээдийн төрөл, ажил гүйлгээний нэр, төрөл, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д заасан дугаарыг тус тус ашиглан бөглөх;

6.2.4.тайлангийн 7.5 дахь харилцан хамааралтай этгээдтэй хийсэн их хэмжээний ажил гүйлгээний нарийвчилсан мэдээлэл хэсэгт – компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний онцлог, шинж чанар, зориулалт, мөнгөн тэмдэгт, мэдээлэл, тээвэрлэлт, төлбөр төлөх, хүлээн авах мөнгөний урсгал, ажил гүйлгээ явагдсан байр, байршил, мөн групп хоорондын ажил гүйлгээ, биет бус хөрөнгөтэй холбоотой ажил гүйлгээг тусгайлан дэлгэрэнгүй мэдээллийг бичгэн хэлбэрээр;

6.2.5.тайлангийн 7.6 дахь өмнөх болон тухайн татварын жилийн харьцуулагдах байдлын шинжилгээний талаар хэсэгт – тухайн жилийн ажил гүйлгээ тус бүрээр гүйцэтгэсэн ажил үүрэг, хүлээсэн эрсдэл, ашигласан хөрөнгө /ажиллагсдын тоо/-ийн шинжилгээ, уг шинжилгээг өмнөх онтой харьцуулах, ажил гүйлгээтэй холбоотой гэрээний голлох заалтууд, эрэлт, нийлүүлэлт, тээвэрлэлт, дистрибьютер зэрэг зах зээл, эдийн засгийн төлөв байдал, үйл ажиллагааны стратегийг дэлгэрэнгүйг бичгэн хэлбэрээр;

6.2.6.тайлангийн 7.7 дахь харилцан хамааралтай этгээдүүдтэй хийсэн ажил гүйлгээнд ашигласан үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой арга хэсэгт - ажил гүйлгээ, харилцан хамааралтай этгээд тус бүрээр үнэ шилжилтийн тохируулга хийсэн хамгийн оновчтой арга болон сонгосон шалтгааныг хүснэгтээр;

6.2.7.тайлангийн 7.8 дахь шалгагдах талуудыг сонгосон үзүүлэлт, шалтгаан хэсэгт - харьцуулагдах байдлын шинжилгээнд үндэслэн шалгагдах тал тус бүрээр, тэдгээрийг сонгосон шалгуур үзүүлэлт болон шалтгааныг хүснэгтээр;

6.2.8.тайлангийн 7.9 дэх үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой аргыг хэрэглэсэн дүгнэлт хэсэгт - ажил гүйлгээ тус бүрээр харьцуулагдах байдлын шинжилгээ, шалгагдах талуудыг сонгосон шалтгаан, харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ эсвэл харьцуулагдах талуудад хийсэн тохируулга зэрэгт үндэслэн үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой аргыг хэрэглэсэн дүгнэлтийг бичгээр;

6.2.9.тайлангийн 7.10.А дахь сонгосон харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ /дотоод, гадаад/-ний тайлбар, жагсаалт хэсэгт - харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ /дотоод, гадаад/-ний жагсаалт, сонгосон үндэслэл,

6.2.10.тайлангийн 7.10.Б дэх харьцуулагдах зүйлсийг олж тогтооход ашигласан мэдээллийн эх үүсвэр, тэдгээрийг хайлт хийхэд хэрэглэсэн арга аргачлалыг дэлгэрэнгүй тайлбар хэсэгт – харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ /дотоод, гадаад/-г олж тогтооход ашигласан мэдээллийн эх үүсвэр, тэдгээрийг хайлт хийхэд хэрэглэсэн арга аргачлалыг дэлгэрэнгүй тайлбарыг бичгээр;

6.2.11. тайлангийн 7.10.В дахь сонгосон харьцуулагдах компанийн шалгуур үзүүлэлт хэсэгт – тайлангийн 7.10.А, 7.10.Б-д тусгагдсан мэдээлэлд үндэслэн гаргасан шалгуур үзүүлэлтээр харьцуулагдах компанийг сонгосон болон татгалзсан байдлыг хүснэгтээр;

6.2.12. тайлангийн 7.10.Г дахь сонгосон харьцуулагдах компанийн мэдээлэл хэсэгт – тайлангийн 7.10.В-д сонгогдсон харьцуулагдах компани тус бүрээр сүүлийн жилийн санхүүгийн мэдээлэлд үндэслэн тохируулга хийхийн өмнөх болон дараах холбогдох санхүүгийн харьцааг хүснэгтээр;

6.2.13. тайлангийн 7.11 дэх харьцуулагдах, хяналтаас гадуурх ажил гүйлгээ эсхүл харьцуулагдах талуудад хийсэн тохируулгын үзүүлэлт болон хийсэн тохируулгын талаар дэлгэрэнгүй тайлбар хэсэгт - ашигт ажиллагааны түвшин, харьцуулагдах санхүүгийн харьцаа, тухайн гүйлгээний эдийн засгийн ач холбогдол зэрэг тохируулга хийсэн үзүүлэлт, үйл явц, үр дүнгийн дэлгэрэнгүй тайлбарыг бичгээр;

6.2.14. тайлангийн 7.12 дахь үнэ шилжилтийн аргуудыг хэрэглэх үед болон хэрэглэсний дараа ашигласан санхүүгийн мэдээллийн нэгтгэл хэсэгт - үнэ шилжилтийн хамгийн тохиромжтой аргуудыг хэрэглэх үед болон хэрэглэсний дараа сүүлийн 4 жилийн санхүүгийн мэдээлэлд тохируулга хийсэн үзүүлэлтийг хүснэгтээр /тухайн татвар төлөгчийн/;

6.2.15. тайлангийн 7.13 дахь тайлангийн сонгосон харьцуулагдах компаниудын квартилийн хязгаар (Inter-quartile range) хэсэгт - сонгосон харьцуулагдах компаниудыг үнэлэхийн тулд бодит үнэ тодорхойлох зарчмаар тооцсон үр дүнгийн хязгаарт багтаж байгааг хүснэгтээр;

6.2.16. тайлангийн 7.14 дэх /ажил гүйлгээг бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу тодорхойлсон/ дүгнэлт хэсэгт - бодит үнэ тодорхойлох зарчмын дагуу ажил гүйлгээний үнийг тодорхойлсон талаарх дэлгэрэнгүй дүгнэлтийг ажил гүйлгээ тус бүрээр бичгээр;

6.3. Санхүүгийн мэдээлэл болон гэрээний талаар:

6.3.1. тайлангийн 8.1 дэх татвар төлөгчийн санхүүгийн тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайлан хэсэгт - дээрх дүн шинжилгээтэй холбоотой санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг “pdf” файлаар хавсарган ирүүлэхийг зэрэгцээ хавсаргасан тайлангийн жагсаалтыг хүснэгтээр;

6.3.2. тайлангийн 8.2 дахь дээрх харилцан хамааралтай гүйлгээтэй холбоотой гадаад орны татварын байгууллагатай байгуулсан хоёр талт болон олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, тэдгээрийн гаргасан дүрэм, журмын хуулбар /pdf файлаар хавсаргана/ хэсэгт – үнэ шилжилттэй холбоотой гадаад орны татварын байгууллагатай байгуулсан хоёр талт болон олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, тэдгээрийн гаргасан дүрэм, журмын хуулбарыг “pdf” файлаар хавсарган ирүүлэхийг зэрэгцээ хавсаргасан гэрээ, журмын жагсаалтыг хүснэгтээр;

6.3.3. тайлангийн 8.3 дахь татвар төлөгч харилцан хамааралтай этгээдийн хооронд байгуулсан их хэмжээний гэрээ, хэлцлийн хуулбар хэсэгт - компанийн хуулийн 87 дугаар зүйлд заасан их хэмжээний хэлцэлд тооцогдох харилцан хамааралтай этгээдтэй байгуулсан их хэмжээний гэрээ, хэлцлийн хуулбарыг “pdf” файлаар хавсарган ирүүлэхийг зэрэгцээ хавсаргасан гэрээний жагсаалтыг хүснэгтээр.

7. Энэ тайлангийн нөхөх зааврын 6 дахь хэсэгт заасан мэдээллийг бүрэн ирүүлсэн эсэх, ирүүлээгүй шалтгааныг дотоод үнэ шилжилтийн тайлангийн баримтжуулалтын бүрдэл хэсэгт хүснэгтээр.



ТЕГ-ын даргын 2019 оны ... сарын
... өдрийн ... тушаалын ... хавсралт

Монголын Татварын Алба

Маягт ЕҮШТ-02

ЕРӨНХИЙ ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАН

1. ТТД | | | | | | | | | | | |

2. Нэр: _____

3. Хариуцлагын хэлбэр: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагааны чиглэл _____
код | | | | | | | |

5. Тайлант хугацаа: он | | | | | улирал | |

6. ГРУПП БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

6.1. Групп болон группийн оролцогчдын ерөнхий мэдээлэл

№	Компанийн нэр	Товчилсон нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Татвар төлөгчийн дугаар	Байнгын хаяг	Албан ёсны цахим хуудасны хаяг
0	1	2	3	4	5	6

6.2. Групп болон группийн оролцогчдын шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал (Зурган хэлбэрээр оруулна)

6.3. Групп болон группийн оролцогчдын удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл (Зурган хэлбэрээр оруулна)

6.4. Групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүргийн хуваарилалт, зохион байгуулалтын талаарх мэдээлэл (Зурган болон бичгийн хэлбэрээр оруулна)



7.1.Бизнесийн үйл ажиллагаа, ашгийг тодорхойлох гол хүчин зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

--

д/д	Ажил гүйлгээний нэр, төрөл	Эзлэх хувь	Борлуулалтын орлогын нийт дүн(төгрөг)	Бараа, ажил үйлчилгээний талаарх тайлбар
1				
2				
3				
4				
5				
6				
7				
8				
9				
10				

Ажил үйлчилгээ үзүүлэгч		Ажил үйлчилгээ хүлээн авагч		Ажил үйлчилгээний нийт дүн(төгрөг)	Ажил үйлчилгээний товч утга, үзүүлэлт	Үнэ шилжилтийн бодлого
Компанийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Компанийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код			

Зах зээл А:

Зах зээл Б:

Зах зээл В:

Зах зээл Г:

Зах зээл Д:



--

[illegible]

А.Биет бус хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

Б. Группийн биет бус хөрөнгийн судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хариуцсан компани, түүний нэгж:

В.Биет бус хөрөнгийн үйл ажиллагаанд баримтлах группийн үнэ шилжилтийн бодлого:

[illegible]

8.3.Биет бус хөрөнгөтэй холбоотой гэрээний жагсаалт

(зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээ, судалгаа хөгжүүлэлтийн үйлчилгээний гэрээ, лицензийн гэрээ)

Гэрээний талууд		Биет бус хөрөнгийн нэр, төрөл	Гэрээний нөхцөл	Гэрээний гол зүйл, заалт
Хэрэглэгч этгээдийн нэр	Эзэмшигч этгээдийн нэр			

8.4.Тайлант хугацаанд групп болон группийн оролцогч хооронд биет бус хөрөнгийн хувь оролцоог шилжүүлэхэд олгосон төлбөрийн мэдээлэл

Биет бус хөрөнгийн нэр, төрөл	Шилжүүлсэн огноо	Шилжүүлэгч тал		Шилжүүлэн авагч тал		Ажил гүйлгээний төлбөрийн дүн /төгрөг/
		Компанийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Компанийн нэр	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	

9. ГРУППИЙН БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**9.1.Группийн хэмжээн дэх санхүүжилтийн бодлого (Гуравдагч талаас авсан санхүүжилтийн гэрээг мөн хамруулна.)**

Санхүүжилт олгосон компанийн нэр	Санхүүжилт хүлээн авсан компанийн нэр	Харилцан хамааралгүй зээлдэгч компанийн нэр	Санхүүжилтийн хэлбэр	Санхүүжүүлсэн дүн /төгрөг/	Хүүний хувь хэмжээ /%/	Хүүний зардлын дүн /төгрөг/

9.2.Группийн доторх санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан группийн оролцогчдын дэлгэрэнгүй мэдээлэл

Группийн оролцогч санхүүжүүлэгч компанийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код	Удирдах байгууллага байрладаг улсын код	Санхүүжилтийн зориулалт, утга

9.3.Группийн доторх санхүүжилтийн гэрээнд баримтлах үнэ шилжилтийн бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл (бонд, зээл, бусад)

Санхүүгийн гүйлгээний нэр, төрөл	Гэрээний талууд		Үнэ шилжилтийн бодлого
	Зээлдүүлэгч компанийн нэр	Зээлдэгч компанийн нэр	



10.ГРУППИЙН БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН САНХҮҮ БОЛОН ТАТВАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

10.1.Тайлант хугацаанд группийн нэгтгэсэн санхүүгийн жилийн тайлан, санхүү, татвар болон бусад зорилгоор бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн жагсаалт /pdf файлаар хавсаргана/

д/д	Компанийн нэр	Санхүүгийн тайлангийн төрөл	Санхүүгийн жил	Хуудасны тоо	Тайлангийн зориулалт

10.2.Гадаадын бусад орнуудад ашиг хуваарласантай холбоотой тэдгээр орнуудын татварын дүрэм, журам, групп, түүний оролцогчдын байгуулсан олон талт урьдчилан үнэ тохирох гэрээний жагсаалт /хоёр талт болон олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, харилцан тохирох журам, бусад гэрээ/

Гэрээний төрөл	Татвар төлөгчөөр харьяалах улсын код	Гэрээний хамрах хүрээ	Гэрээг хэрэгжүүлэх хугацаа	Үнэ шилжилтийн арга

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /захирал/:

..... /...../
гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын байцаагч:

..... /...../
гарын үсэг нэр

20... оны ... сарын ... өдөр



**ЕРӨНХИЙ ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН
БАРИМТЖУУЛАЛТЫН БҮРДЭЛ**

Үзүүлэлт	Хуудасны дугаар	Ирүүлээгүй шалтгаан
6. ГРУПП БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:		
6.1. Групп болон группийн оролцогчдын ерөнхий мэдээлэл		
6.2. Групп болон группийн оролцогчдын шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал /Зурган хэлбэрээр оруулна/		
6.3. Групп болон группийн оролцогчдын удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл /Зурган хэлбэрээр оруулна/		
6.4. Групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүргийн хувиарлалт, зохион байгуулалтын талаарх мэдээлэл /Зурган болон бичгийн хэлбэрээр оруулна/		
7. ГРУПП БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:		
7.1. Бизнесийн үйл ажиллагаа, ашгийг тодорхойлох гол хүчин зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл		
7.2. Группийн нийт борлуулалтын орлогын дүнгийн 5 ба түүнээс дээш хувийг эзэлж буй хамгийн их 10 борлуулалтын орлогын мэдээлэл /ажил гүйлгээний нэр, төрлөөр/		
7.3. Группийн оролцогчдын этгээдийн хооронд байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний жагсаалт		
7.4. Бараа, ажил үйлчилгээний зах зээлийн нөхцөл байдлын (газарзүйн бүс болон улс бүрээр) дэлгэрэнгүй мэдээлэл		
7.5. Группийн оролцогч бүрийн үнэ цэнийг үүсгэж байгаа хувь оролцоог илэрхийлсэн ажил үүргийн шинжилгээ /гүйцэтгэсэн ажил үүрэг, хариуцсан эрсдэл, ашигласан хөрөнгө гэх мэт/		
7.6. Тухайн тайлант хугацаанд группийн оролцогчдын бизнесийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой болон компани худалдан авсан, борлуулсан ажил гүйлгээний талаарх мэдээлэл		
8. ГРУПП БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН БИЕТ БУС ХӨРӨНГӨ:		
8.1. Группийн биет бус хөрөнгийг эзэмших, хөгжүүлэх ерөнхий стратеги, бодлогын талаарх мэдээлэл /гол судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хариуцсан компани, түүний нэгж, удирдлагын үйл ажиллагааг хариуцсан компани, түүний нэгжийн байршлыг тусгана/		
8.2. Группийн болон группийн оролцогчдын эзэмшиж байгаа биет бус хөрөнгийн жагсаалт		
8.3. Биет бус хөрөнгөтэй холбоотой гэрээний жагсаалт /зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээ, судалгаа хөгжүүлэлтийн үйлчилгээний гэрээ, лицензийн гэрээ/		
8.4. Тайлант хугацаанд харилцан хамааралтай этгээдийн хооронд биет бус хөрөнгийн хувь оролцоог шилжүүлэхэд олгосон төлбөрийн мэдээлэл		
9. ГРУППИЙН БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА		
9.1. Группийн хэмжээн дэх санхүүжилтийн бодлого /Гуравдагч талаас авсан санхүүжилтийн гэрээг мөн хамруулна/		
9.2. Группийн доторх санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан группийн оролцогч компанийн дэлгэрэнгүй мэдээлэл		
9.3. Группийн доторх санхүүжилтийн гэрээнд баримтлах үнэ шилжилтийн бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл /бонд, зээл, бусад/		
10. ГРУППИЙН БОЛОН ГРУППИЙН ОРОЛЦОГЧДЫН САНХҮҮ БОЛОН ТАТВАРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ		
10.1. Тайлант хугацаанд группийн нэгтгэсэн санхүүгийн жилийн тайлан, санхүү, татвар болон бусад зорилгоор бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн жагсаалт /pdf файлаар хавсаргана/		
10.2. Гадаадын бусад орнуудад ашиг хуваарласантай холбоотой тэдгээр орнуудын татварын дүрэм, журам, групп, түүний оролцогчдын байгуулсан олон талт урьдчилан үнэ тохирох гэрээний жагсаалт /хоёр талт, олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, Харилцан тохирох журам, бусад гэрээ		

“ЕРӨНХИЙ ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН (ЕҮШТ-02) МАЯГТ”-ЫГ НӨХӨХ ЗААВАР

1.Татвар төлөгч нь ерөнхий үнэ шилжилтийн тайланг Татварын Ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д заасан хугацаанд энэ маягтаар гаргаж, татварын албанд тушаана. Тайланг гаргахдаа Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан “Үнэ шилжилтийн зөвлөмж”, “Үнэ шилжилтийн тайлан гаргах удирдамж”, Сангийн сайдын 2019 оны ... дугаар сарын... өдрийн ... дүгээр тушаалаар батлагдсан “Үнэ шилжилтийн тохируулга хийх хамгийн тохиромжтой аргыг сонгох, хэрэглэх журам”-ыг баримтална.

2.Татвар төлөгч нь тайлангийн маягтаар групп болон группийн оролцогч этгээдийн бүтэц зохион байгуулалт, бизнесийн үйл ажиллагаа, биет бус хөрөнгө, санхүүгийн үйл ажиллагаа, санхүү болон татварын нөхцөл байдал зэрэг группийн хэмжээний мэдээллийг өссөн дүнгээр гаргана.

3.Харилцан хамааралтай этгээдийн ангилал, харилцан хамаарлын төрөл, харилцан хамаарлын хэлбэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код, бараа, ажил гүйлгээний нэр, төрөл хэсгийг хавсралт 3-т заасан дугаарыг ашиглан бөглөнө.

4.Энэ тайлангийн маягтад дурдсан үйл ажиллагааны чиг үүргийн хуваарилалт, бизнесийн үйл ажиллагаа, биет бус хөрөнгө зэрэг бичгийн хэлбэрээр бэлтгэх мэдээллийг дэлгэрэнгүй, утга санаа нь ойлгомжтой,тодорхой, нотлогдохуйц байдлаар боловсруулна.

5.Татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.3-т заасны дагуу үнэ шилжилтийн тайлантай холбогдох нэмэлт мэдээллийг татварын албанд тухай бүр гаргаж өгнө.

6.Татвар төлөгч нь энэ тайланг боловсруулахдаа Татварын ерөнхий Хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасан дараах шаардлагатай мэдээллүүдийг бүрэн тусгасан байна:

6.1.Групп болон группийн оролцогчдын бүтэц зохион байгуулалтын талаар:

6.1.1.тайлангийн 6.1 дэх групп болон группийн оролцогчдын ерөнхий мэдээлэл хэсэгт –Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д заасан групп хамаарах аж ахуйн нэгж нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсаас олгосон татвар төлөгчийн дугаарыг, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, регистрийн дугаарыг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, байнгын хаяг, албан ёсны цахим хуудасны хаяг зэрэг ерөнхий мэдээллийг хүснэгтээр;

6.1.2.тайлангийн 6.2 дахь групп болон группийн оролцогчдын шууд болон шууд бус оролцоотой хувь эзэмшигчдийн бүтцийн зураглал хэсэгт- групп болон түүнд хамаарах аж ахуйн нэгжүүдийн гаргасан нийт хувьцаа, саналын эрхийг шууд болон шууд бусаар эзэмшиж буй харилцан хамааралтай этгээдийн хувь оролцоо, харьяалагдах улс, эсвэл байршил болон үргэлжилсэн хэлхээ холбоог бүдүүвч зургаар;

6.1.3.тайлангийн 6.3 дахь групп болон группийн оролцогчдын удирдлагын бүтэц, зохион байгуулалтын талаарх мэдээлэл хэсэгт– группийн хэмжээнд удирдлага, эрх бүхий албан тушаалтанд хамаарах групп болон группийн оролцогчдын удирдлагыг шатлан захирах зарчмаар байршуулсан бүтэц, зохион байгуулалтыг /группийн оролцогчдын нэр, байршил, албан тушаал/ бүдүүвч зургаар;

6.1.4.тайлангийн 6.4 дэх групп болон группийн оролцогчдын үйл ажиллагааны чиг үүргийн хуваарилалт, зохион байгуулалтын талаарх мэдээлэл хэсэгт- группийн үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгж тус бүрийн нийлүүлэлтийн гинжин удирдлагад хамаарах үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх ажил үүргийн хуваарилалт, ажиллагсдын тоо болон бусад холбогдох мэдээллийг бүдүүвч зургаар болон бичгэн хэлбэрээр;

6.2.Групп болон группийн оролцогчдын бизнесийн үйл ажиллагааны талаар:

6.2.1.тайлангийн 7.1 дэх бизнесийн үйл ажиллагаа, ашгийг тодорхойлох гол хүчин зүйлсийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт– группийн үйл ажиллагаа чиглэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээ, газарзүйн бүсээрх зах зээл, худалдан авагч, нийлүүлэгч, гол өрсөлдөгч компаниуд, бизнесийн стратеги, бодлого, үйлдвэрлэл, зах зээл, эдийн засаг, хууль эрхзүйн төлөв байдал, тайлант хугацаанд гарсан группийн оролцогчдын бүтцийн, бизнесийн томоохон өөрчлөлт, ашигт нөлөө үзүүлж буй гол хүчин зүйлс, бусад холбогдох мэдээллийг бичгэн хэлбэрээр;

6.2.2.тайлангийн 7.2 дахь группийн нийт борлуулалтын орлогын дүнгийн 5 ба түүнээс дээш хувийг эзэлж буй хамгийн их 10 борлуулалтын орлогын мэдээлэл хэсэгт- группийн нийт борлуулалтын орлогын дүнгийн 5 ба түүнээс дээш хувийг эзэлж буй хамгийн их 10 бараа, ажил үйлчилгээ тус бүрийн борлуулалтын орлого, түүний нийт орлогод эзэлж буй хувь хэмжээ, бараа ажил үйлчилгээний тайлбар зэрэг мэдээллийг хүснэгтээр;

6.2.3.тайлангийн 7.3 дахь группийн оролцогчдын хооронд байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний жагсаалт хэсэгт- группийн оролцогчдын хооронд байгуулсан ажил, үйлчилгээний гэрээ (Intra-group service)-г үндэслэн гэрээний оролцогч талууд нь Монгол улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг ашиглана. Ажил үйлчилгээний нийт дүн, товч утга, үзүүлэлт, группийн оролцогчдын хоорондох ажил үйлчилгээнд баримтлах үнэ шилжилтийн бодлогыг хүснэгтээр;

6.2.4.тайлангийн 7.4 дэх бараа, ажил үйлчилгээний зах зээлийн төлөв байдлын дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт- газарзүйн бүс болон улс бүрээр бараа ажил үйлчилгээний зах зээлийг онцлог шинж, зарчим зэрэг зах зээлийн дэлгэрэнгүй мэдээллийг бичгэн хэлбэрээр;

6.2.5.тайлангийн 7.5 дахь группийн оролцогч бүрийн үнэ цэнийг үүсгэж байгаа хувь оролцоог илэрхийлсэн ажил үүргийн шинжилгээ хэсэгт- үндэстэн дамнасан группийн үнэ цэнийг нэмэгдүүлж байгаа группийн оролцогч бүрийн гүйцэтгэсэн ажил үүрэг, хариуцсан эрсдэл, ашигласан хөрөнгийн шинжилгээг бичгэн хэлбэрээр;

6.2.6.тайлангийн 7.6 дахь тухайн тайлант хугацаанд группийн оролцогчдын бизнесийн бүтцийн өөрчлөлттэй холбоотой ажил гүйлгээний талаарх мэдээлэл хэсэгт- групп хамаарах аж ахуйн нэгж нь Монгол улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр(оноосон нэрээр),Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэрийг,тэдгээрийн хувь эзэмшигчдийн өөрчлөлт, худалдан авсан, зарсан, нийлсэн, нэгдсэн, татан буугдсан зэрэг ажил гүйлгээний нэр төрөл, гүйлгээ хийсэн огноо, нийт дүнг хүснэгтээр;

6.3.Групп болон группийн оролцогчдын биет бус хөрөнгө:

6.3.1.тайлангийн 8.1 дэх группийн биет бус хөрөнгийг эзэмшил, хөгжүүлэх ерөнхий стратеги, бодлогын талаарх мэдээлэл хэсэгт- групп болон группийн оролцогчдын эзэмшиж, ашиглаж, хөгжүүлж, бүтээж, бий болгож байгаа биет бус хөрөнгийн жагсаалт, группийн биет бус хөрөнгийн стратеги, судалгаа хөгжүүлэлтийн үйл ажиллагааг хариуцсан компани, түүний нэгж, удирдлагын үйл ажиллагааг хариуцсан компанийн чиг үүрэг, тэдгээрийн байршлыг, биет бус хөрөнгийн үйл ажиллагаанд баримтлах группийн үнэ шилжилтийн бодлогыг бичгэн хэлбэрээр;

6.3.2.тайлангийн 8.2 дахь группийн болон группийн оролцогчдын эзэмшиж байгаа биет бус хөрөнгийн жагсаалт хэсэгт- группийн болон группийн оролцогчид нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан

нэрийг, биет бус хөрөнгийн нэр, төрөл, бүртгүүлсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, биет бус хөрөнгийн товч утга, агуулга зэрэг мэдээллийг хүснэгтээр;

6.3.3.тайлангийн 8.3 дахь биет бус хөрөнгөтэй холбоотой гэрээний жагсаалт хэсэгт- зардлыг санхүүжүүлэхэд хувь оруулах гэрээ, зардал хуваах гэрээ, судалгаа хөгжүүлэлтийн үйлчилгээний гэрээ, лицензийн гэрээ, бусад холбогдох гэрээг үндэслэн гэрээний талууд болох хэрэглэгч, эзэмшигч этгээд нь Монгол улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэрийг, биет бус хөрөнгийн нэр, төрөл, гэрээний нөхцөл, гол зүйл, заалтын талаарх мэдээллийг хүснэгтээр;

6.3.4.тайлангийн 8.4 дэх тайлант хугацаанд групп болон группийн оролцогч хооронд биет бус хөрөнгийн хувь оролцоог шилжүүлэхэд олгосон төлбөрийн мэдээлэл хэсэгт- шилжүүлсэн биет бус хөрөнгийн нэр, төрөл, огноо, шилжүүлэгч болон шилжүүлэн авагч тал нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэрийг, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг, ажил гүйлгээний төлбөрийн дүн зэрэг мэдээллийг хүснэгтээр;

6.4.Группийн болон группийн оролцогчдын санхүүгийн үйл ажиллагаа:

6.4.1.тайлангийн 9.1 дэх группийн хэмжээн дэх санхүүжилтийн бодлого хэсэгт- санхүүжилт олгосон,санхүүжилт хүлээн авсан,харилцан хамааралгүй зээлдэгч компани нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг тохиолдолд улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэрийг, санхүүжилтийн хэлбэр /зээл, өрийн бичиг, бонд гэх мэт/, дүн, хүүний хувь хэмжээ, хүүгийн зардлын дүнг хүснэгтээр;

6.4.2.тайлангийн 9.2 дахь хэсэгт группийн доторх санхүүгийн үйл ажиллагаа хариуцсан группийн оролцогчдын дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт- группийн оролцогч санхүүжүүлэгч компани нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр /оноосон нэрээр/, Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэр, байнгын татвар төлөгчөөр бүртгэгдсэн улсын код, удирдах байгууллага байрладаг улсын кодыг хавсралт 3-т заасан харгалзах дугаарыг ашиглан бөглөнө. Тус этгээдийн үйл ажиллагааны чиглэлийг “Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал”-д заасныг, санхүүжилтийн зориулалт зэрэг мэдээллийг хүснэгтээр;

6.4.3.тайлангийн 9.3 дахь группийн доторх санхүүжилтийн гэрээнд баримтлах үнэ шилжилтийн бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл хэсэгт- санхүүгийн гүйлгээний нэр,төрөл, зээлдүүлэгч, зээлдэгч компани нь Монгол Улсад байрладаггүй тохиолдолд тус этгээдийн нэрийг англи хэлээр (оноосон нэрээр), Монгол Улсад байрладаг бол улсын бүртгэлийн гэрчилгээнд заасан нэрийг, гүйлгээ тус бүрээр группийн доторх санхүүжилтийн гэрээнд баримтлах үнэ шилжилтийн бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хүснэгтээр;

6.5 Группийн болон группийн оролцогчдын санхүү болон татварын төлөв байдал:

6.5.1.тайлангийн 10.1 дэх тайлант хугацаанд группийн нэгтгэсэн санхүүгийн жилийн тайлан, санхүү, татвар болон бусад зорилгоор бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн жагсаалт хэсэгт-группийн нэгтгэсэн санхүүгийн жилийн тайлан, санхүү, татвар болон бусад зорилгоор бэлтгэсэн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг pdf файлаар хавсарган ирүүлэхийг зэрэгцээ хавсаргасан тайлангийн жагсаалтыг хүснэгтээр;

6.5.2.тайлангийн 10.2 дахь гадаадын бусад орнуудад ашиг хуваарилсантай холбоотой тэдгээр орнуудын татварын дүрэм, журам, групп, түүний оролцогчдын байгуулсан олон талт урьдчилан үнэ тохирох гэрээний жагсаал хэсэгт– үнэ шилжилттэй холбоотой гадаад орны татварын байгууллагатай байгуулсан хоёр талт болон олон талт урьдчилан үнэ тохирох гэрээ, харилцан тохирох журам, бусад гэрээ, тэдгээрийн гаргасан ашиг хуваарилсантай холбоотой дүрэм, журмын хуулбарыг pdf

файлаар хавсарган ирүүлэхийг зэрэгцээ хавсаргасан гэрээ, журмын жагсаалтыг хүснэгтээр;

7.Энэ тайлангийн нөхөх зааврын 6 дахь хэсэгт заасан мэдээллийг бүрэн ирүүлсэн эсэх, ирүүлээгүй шалтгааныг ерөнхий үнэ шилжилтийн тайлангийн баримтжуулалтын бүрдэл хэсэгт хүснэгтээр харуулах.



Монголын Татварын Алба

Маягт УБҮШТ-01

УЛС БҮРЭЭР ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАН

1. ТТД | | | | | | | | | | | |

2. Нэр: _____

3. Хариуцлагын хэлбэр: _____

4. Эрхлэх үйл ажиллагаа: Үндсэн үйл ажиллагааны чиглэл _____
код | | | | | | | |

5. Тайлант хугацаа: он | | | | | улирал | |

1. Татвар ногдуулагч улс бүрт ногдох орлого, татвар, бизнесийн үйл ажиллагааны тойм мэдээлэл

Үндэстэн дамнасан группийн нэр: Тайлант хугацаа:										
Татвар ногдуулагч улс	Орлого			Татварын өмнөх ашиг (алдаг- дал)	Төлсөн орлогын албан татвар (мөнгөн суурь)	Орло- гын албан татвары н өр	Хувь нийлү үлсэн хөрөн гийн дүн	Хурим тлагдс ан ашиг	Ажилл агсдын тоо	Мөнгө болон түүнтэй адилтгах зүйлсээс бусад биет хөрөнгө
	Харил- цан хамаа- ралгүй этгээд	Харил- цан хамаа- ралтай этгээд	Нийт							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11

2. Татвар ногдуулагч улсад байрлах группын оролцогчдын харьяалал, бизнесийн үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

Үндэстэн дамнасан группийн нэр: Тайлант хугацаа:															
Татвар ногдуу- лагч улс	Татвар ногдуулагч улсад оршин суудаг группийн оролцогч этгээд	Хуулийн дагуу оршин суугч улсын нэр	Бизнесийн үндсэн үйл ажиллагаа												
			Судалгаа, хөгжүүлэлт	Оюуны өмч эзэмших, захиран зарцуулах	Худалдан авалтын үйл ажиллагаа	Үйлдвэрлэл, боловсруулалт	Борлуулалт, Маркетинг, Түгээлт	Захиргаа, Удирдлага болон дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	Харилцан хамааралгүй этгээдэд үйлчилгээ үзүүлэх	Группийн дотоод санхүү	Санхүүгийн үйлчилгээ	Даатгал	Хувьцаа, эзэмшигч буюу санхүүгийн хөрөнгө	Үйл ажиллагаа явуулаагүй-Идэвхигүй	Бусад
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16
	1.														



	2.														
	3.														
	1.														
	2.														
	3.														
	1.														
	2.														
	3.														

8. НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /захирал/:

..... /...../
гарын үсэг нэр

Ерөнхий нягтлан бодогч:

..... /...../
гарын үсэг нэр

тэмдэг

20... оны ... сарын ... өдөр

Тайланг хүлээн авсан:

Татварын улсын байцаагч:

..... /...../
гарын үсэг нэр

тэмдэг

20... оны ... сарын ... өдөр



“УЛС БҮРЭЭР ҮНЭ ШИЛЖИЛТИЙН ТАЙЛАНГИЙН МАЯГТ”-ЫГ НӨХӨХ ЗААВАР

1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.3-т заасан тайлагнагч этгээд нь Үндэстэн дамнасан группийн /цаашид “ҮДГ” гэх/-ийн санхүүгийн жилийн сүүлийн өдрөөс хойш 12 сарын хугацаанд багтаан энэ маягтаар Улс бүрээр үнэ шилжилтийн тайланг гаргаж, харьяалах татварын албанд тушаана. Тайланг гаргахдаа Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагаас гаргасан “Үнэ шилжилтийн зөвлөмж”, “Үнэ шилжилтийн баримтжуулалтын улс улсаар тайлагнах зөвлөмж”-ийг баримтална.

2.Татвар төлөгч нь энэ тайлангийн маягтаар ҮДГ-ийн оролцогч этгээдийн орлого, татвар, хөрөнгө, ашиг зэрэг санхүүгийн зарим шаардлагатай мэдээллийг татвар ногдуулагч улс бүрээр нэгтгэж, тэдгээрийн бизнесийн үйл ажиллагааны чиглэлийг сонгож тайлагнана.

3.Тайланд тусгаж буй санхүүгийн тоон мэдээлэл нь гадаад валютаар илэрхийлэгдсэн тохиолдолд группийн оролцогч бүрийн санхүүгийн жилийн сүүлийн өдрийн хаалтын ханшийг Монгол банкны тухайн өдрийн ханшид хөрвүүлэн төгрөгөөр илэрхийлнэ.

4.Аж ахуйн нэгийн 27 дугаар зүйлийн 27.5-д заасны дагуу энэ тайланд дараах мэдээллийг тусгана:

4.1. Тайлангийн 1 дэх ҮДГ-ийн оролцогч этгээдийн орлого, татвар болон бизнесийн үйл ажиллагааны хуваарилалтыг татвар ногдуулагч улс бүрээр нь гаргах мэдээлэл хэсэгт – ҮДГ-ийн үйл ажиллагаа явуулж байгаа улс орон бүрт олсон орлого, татварын өмнөх ашиг, төлсөн орлогын албан татвар, орлогын албан татварын өр, хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг, ажиллагчдын тоо, мөнгө болон түүнтэй адилтгах зүйлсээс бусад хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн дүн зэрэг мэдээллийг татвар ногдуулагч улс бүрээр дараах байдлаар нэгтгэн хүснэгтээр.

4.1.1.татвар ногдуулагч улс /1 дүгээр багана/ - татварын зорилгоор ҮДГ-ийн оролцогчдыг байнгын татвар төлөгчөөр бүртгүүлсэн улсыг бичнэ. Хэрэв группийн оролцогч нь нэгээс дээш улсын оршин суугч байвал группийн оролцогчийн голлох удирдлага байрладаг улсын нэрийг;

4.1.2.харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн ажил гүйлгээний орлогын дүн /2 дугаар багана/-татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын харилцан хамааралгүй этгээдтэй хийсэн борлуулалтын орлогын нийт дүнг нөхнө. Орлогод бараа материал, хөрөнгийн борлуулалт, үйлчилгээ, эрхийн шимтгэл, хүү, урамшуулал болон бусад орлогыг хамааруулах;

4.1.3.харилцан хамааралтай этгээдтэй хийсэн ажил гүйлгээний орлогын дүн /3 дугаар багана/-татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын харилцан хамааралтай этгээдтэй хийсэн борлуулалтын орлогын нийт дүнг;

4.1.4.нийт орлого /4 дүгээр багана/- нөхөх зааврын 4.1.2, 4.1.3-т тодорхойлсон орлогын нийлбэр дүнг;

4.1.5.татварын өмнөх ашиг, алдагдал /5 дугаар багана/-д татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын орлого, үр дүнгийн тайланд үндэслэн орлогын албан татварын өмнөх ашиг, алдагдлын дүнг;

4.1.6.төлсөн орлогын албан татвар /6 дугаар багана/- татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын мөнгөөр төлсөн орлогын албан татварын нийт дүнг тайлагнана. Төлсөн орлогын албан татварт группийн оролцогчдын байрлаж буй тухайн улсад төлсөн болон бусад улсуудад суутгуулан төлсөн татварын нийлбэр дүнгээр тайлагнана. Жишээлбэл: татвар ногдуулагч “А” улсад байрладаг “А” компани нь татвар

ногдуулагч “Б” улсад олсон хүүгийн орлогоос “Б” улсад суутгуулан төлсөн татварыг “А” улсад төлсөн татварын дүн дээр нэмж тайлагнах;

4.1.7. орлогын албан татварын өр /7 дугаар багана/- группийн оролцогчдын татвар ногдуулагч улсад ногдуулсан татварын дүнгээс нөхөх зааврын 4.1.6-д заасан төлсөн татварын дүнг хасаж, татварын өрийн дүнг гаргаж тайлагнана. Татварын өрийн дүнд тухайн жилийн хойшлуулсан татварын дүн болон тодорхойгүй татварыг хамааруулахгүй;

4.1.8. хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн /8 дугаар багана/- татвар ногдуулагч улсад байрлаж байгаа группийн оролцогчдын хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгийн нийлбэрийг тайлагнана. Төлөөний газрын хувьд төлөөний газрыг харьяалах этгээд нь тус төлөөний газрын хөрөнгийг тайлагнах;

4.1.9. хуримтлагдсан ашиг /9 дүгээр багана/-д татвар ногдуулагч улсад байрлаж байгаа группийн оролцогчдын хуримтлагдсан ашгийн нийлбэр дүнгээр тайлагнана. Төлөөний газрын хувьд, төлөөний газрыг харьяалах этгээд нь тайлагнах;

4.1.10. ажиллагсдын тоо /10 дугаар багана/- татвар ногдуулагч улсад байрлаж байгаа группийн оролцогчдын үндсэн ажиллагсдын тоог тухайн жилийн дунджаар гарган тайлагнах;

4.1.11. мөнгө болон түүнтэй адилтгах зүйлсээс бусад биет хөрөнгө /11 дүгээр багана/- татвар ногдуулагч улсад байрлаж байгаа группийн оролцогчдын хөдлөх, үл хөдлөх хөрөнгийн дансны цэвэр үлдэгдлийн дүнгийн нийлбэрээр тайлагнах.

4.2. Тайлангийн 2 дахь татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын харьяалал, бизнесийн үндсэн үйл ажиллагааны талаарх мэдээлэл хэсэгт- группийн оролцогчдын хуулийн этгээдийн нэр, оршин суугч улс, бизнесийн үйл ажиллагааны төрлийн мэдээллийг дараах байдлаар тайлагнана.

4.2.1. татвар ногдуулагч улс /1 дүгээр багана/- группийн оролцогчдын татварын зорилгоор оршин суудаг татвар ногдуулагч улсын нэрийг англи хэлээр бичнэ. Төлөөний газрын хувьд тус төлөөний газрын байрлаж байгаа улсын нэрийг;

4.2.2. татвар ногдуулагч улсад үйл ажиллагаа явуулж байгаа группийн оролцогч этгээд /2 дугаар багана/- хуулийн этгээд тус бүрийн нэрийг оноосон нэрийг англи хэлээр бичнэ. Төлөөний газрын хувьд, тус төлөөний газрын байрлаж байгаа улсыг;

4.2.3. хуулийн дагуу оршин суугч улс /3 дугаар багана/- хэрэв группийн оролцогч этгээдийн татварын зорилгоор байрладаг улс нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан улсаас өөр бол тухайн хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн улсын нэрийг англи хэлээр;

4.2.4. татвар ногдуулагч улсад байрлах группийн оролцогчдын бизнесийн үйл ажиллагааны төрлийг тайлагнахдаа, 4-15 дугаар баганад байгаа төрлүүдээс нэг болон хэд хэдийг сонгож √ тэмдэглэгээ хийн, хэрэв баганад байхгүй төрөл байвал 16 дугаар баганад дэлгэрэнгүй бичиж тайлагнах.

4.3. Тайлангийн 3 дахь нэмэлт мэдээлэл хэсэгт- ҮДГ-тэй холбоотой нэмэлт мэдээлэл буюу группийн оролцогчдын үйл ажиллагааны онцлог, эсхүл энэ тайланд тусгагдаагүй, тайланд тусгасан мэдээллийг ойлгоход туслах нэмэлт мэдээлэл, тухайлбал маягтыг бөглөхөд ашигласан тоон мэдээллийн эх сурвалжийн товч тайлбар, хэрэв жил бүр ашигладаг байсан тоон мэдээллийн эх сурвалжийг өөрчилсөн бол өөрчлөлт хийсэн шалтгаан, гарах үр дүн зэрэг шаардлагатай гэж үзэж байгаа бусад мэдээллийг тайлбарын хамт бичнэ.